



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Гурванбулаг сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/100/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.bulgan@audit.gov.mn Булган аймаг Булган сум 2023 он	Булган аймаг дахь ТАГ-н дарга, Тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 89009802 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 99057478 Цахим хаяг: enhtsoodolj@audit.gov.mn Ахлах аудитор: Утас: Цахим хаяг: Аудитор: Б.Золжаргал Утас: 90119931 Цахим хаяг: zoljargalb@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
.....
 - 4.2 Материаллаг байдал
.....
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
.....

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс:7034-2580
E-mail:bulgan@audit.gov.mn

АХБ О.Л. 24 № 102

танай _____ ны № _____ т

ГУРВАНБУЛАГ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Д.ТУНГАЛАГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гурванбулаг сумын Цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гурванбулаг сумын Цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Цэцэрлэг нь 2022 онд улсын төсвөөс 315.7 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 52.6 сая төгрөг, нэмэлт санхүүжилтийн орлого 2.3 сая төгрөгийн санхүүжилт авч ажиллажээ.

Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 995.9 сая төгрөгийн 75 ортой Цэцэрлэгийн барилгын өргөтгөлийг хүлээж авч Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 186 тоот тогтоолын дагуу бүртгэлд тусгасан байна.

D:\pichighereg\2022A4\toot

006020258

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	72,351,225.00	97,127,375.99
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	10,923,362.99
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	10,923,362.99
3121	Төгрөг	-	10,923,362.99
31211	Төрийн сангийн харилцах	-	10,923,362.99
35	БАРАА МАТЕРИАЛ	72,351,225.00	86,204,013.00
354	Хангамжийн материал	72,351,225.00	86,204,013.00
35410	Бичиг хэргийн материал	425,800.00	81,500.00
35420	Аж ахуйн материал	62,327,389.00	73,326,091.00
35450	Барилгын засварын материал	957,400.00	248,500.00
35460	Хүнсний материал	5,781,686.00	9,490,672.00
35470	Бусад хангамжийн материал	2,858,950.00	3,057,250.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	211,468,504.12	1,196,466,923.53
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	211,468,504.12	1,196,466,923.53
392	Биет хөрөнгө	195,054,004.12	1,180,221,173.53
39201	Барилга, байгууламж, орон сууц	167,205,437.98	1,157,860,276.58
39202	Хуримтлагдсан элэгдэл	(24,793,621.80)	(29,818,663.50)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	37,488,318.00	44,316,718.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(7,742,289.56)	(11,172,708.11)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,264,681.75	39,558,886.75
39208	Хуримтлагдсан элэгдэл	(17,788,908.25)	(21,943,722.19)
39217	Ном	1,420,386.00	1,420,386.00
393	Биет бус хөрөнгө	16,414,500.00	16,245,750.00
39301	Програм хангамж	1,350,000.00	1,350,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(337,500.00)	(506,250.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	15,402,000.00	15,402,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	283,819,729.12	1,293,594,299.52
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	660,890.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	660,890.00
413	Өглөг	-	660,890.00
4136	Бусад өглөг	-	660,890.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	615,890.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	45,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	241,664,745.12	1,292,933,439.52
51	Засгийн газрын хувь оролцоо	241,664,745.12	1,292,933,439.52
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	-	42,154,984.00
512	Хуримтлагдсан үр дүн	117,038,325.22	1,130,658,446.90
51210	Өмнөх үеийн үр дүн	117,038,325.22	121,544,736.50
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,009,113,710.40
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	124,626,419.90	120,120,008.62
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	241,664,745.12	1,293,594,329.52

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	314,730,562.37	1,394,393,845.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	73,600.00	1,012,759,145.00
120	Нийтлэг татварын бус орлого	73,600.00	1,012,759,145.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	73,600.00	995,938,510.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		995,938,510.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	73,600.00	-
120005	Түрээсийн орлого		16,820,635.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	314,656,962.37	381,634,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	294,460,500.00	326,595,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	326,595,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	294,460,500.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	780,000.00	2,395,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	580,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	200,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	2,395,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	19,416,462.37	52,644,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	19,416,462.37	52,644,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	334,714,186.17	381,405,442.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	334,714,186.17	381,405,442.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	288,582,227.94	381,395,419.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	203,904,642.41	244,636,375.00
210101	Үндсэн цалин	148,171,373.81	186,240,821.00
210102	Нэмэгдэл	37,919,437.60	49,483,600.00
210104	Урамшуулал	17,813,831.00	8,911,954.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,060,279.40	30,677,127.01
210201	Тэтгэврийн даатгал	19,257,480.80	20,874,585.83
210202	Тэтгэмжийн даатгал	1,959,166.14	2,452,466.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,567,432.40	1,961,913.41
210204	Ажилгүйдлийн даатгал	383,271.98	483,128.02
210205	Эрүүл мэндийн даатгал	3,892,928.08	4,905,032.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,015,962.37	40,787,122.00
210301	Гэрэл, цахилгаан	1,156,142.37	2,040,122.00
210302	Түлш, халаалт	17,859,820.00	38,747,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,012,382.00	3,676,928.00
210401	Бичиг хэрэг	321,400.00	175,600.00
210402	Тээвэр, шатахуун	2,523,700.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	350,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	648,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,169,282.00	3,501,328.00
2105	Нормативт зардал	11,017,028.00	35,923,704.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	56,600.00	-
210502	Хоол, хүнс	9,829,028.00	35,923,704.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,131,400.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,538,000.00	1,661,900.00
210604	Урсгал засвар	1,538,000.00	1,661,900.00
2107	Томилолт, зочны зардал	42,000.00	-
210702	Дотоод албан томилолт	42,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний	230,000.00	400,000.00

	төлбөр, хураамж		
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	230,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,761,933.76	23,632,263.23
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	235,100.00	7,790,090.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	28,200.00	1,654,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,498,633.76	14,187,973.23
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,131,958.23	10,023.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	600,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	45,531,958.23	10,023.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	45,531,958.23	10,023.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(19,983,623.80)	1,012,988,402.76
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	99,495.00	3,874,692.36
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	99,495.00	3,874,692.36
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(99,495.00)	(3,874,692.36)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(20,083,118.80)	1,009,113,710.40

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	314,656,962.37	381,634,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	314,656,962.37	381,634,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	294,460,500.00	326,595,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	326,595,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	294,460,500.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	780,000.00	2,395,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	580,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	200,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	2,395,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	19,416,462.37	52,644,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	19,416,462.37	52,644,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	312,920,962.37	370,711,337.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	312,920,962.37	370,711,337.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	266,789,004.14	370,701,314.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	203,904,642.37	244,591,375.00
210101	Үндсэн цалин	147,528,387.77	186,195,821.00
210102	Нэмэгдэл	38,562,423.60	49,483,600.00
210104	Урамшуулал	17,813,831.00	8,911,954.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,060,279.40	30,677,127.01
210201	Тэтгэврийн даатгал	19,257,480.80	20,874,585.83
210202	Тэтгэмжийн даатгал	1,959,166.14	2,452,466.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,567,432.40	1,961,913.41
210204	Ажилгүйдлийн даатгал	383,271.98	483,128.02
210205	Эрүүл мэндийн даатгал	3,892,928.08	4,905,032.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,416,462.37	40,787,122.00
210301	Гэрэл, цахилгаан	1,156,142.37	2,040,122.00
210302	Түлш, халаалт	17,260,320.00	38,747,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,554,100.00	-
210401	Бичиг хэрэг	500,000.00	-

210402	Тээвэр, шатахуун	2,523,700.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	350,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,090,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,090,400.00	-
2105	Нормативт зардал	8,616,420.00	39,632,690.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	56,600.00	-
210502	Хоол, хүнс	8,009,220.00	39,632,690.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	550,600.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	42,000.00	-
210702	Дотоод албан томилолт	42,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	230,000.00	814,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	230,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	814,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	965,100.00	13,199,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	965,100.00	11,549,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1,650,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,131,958.23	10,023.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	600,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	45,531,958.23	10,023.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	45,531,958.23	10,023.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,736,000.00</u>	<u>10,923,362.99</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,736,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,736,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	1,736,000.00	-
222001	Тоног төхөөрөмж	1,736,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(1,736,000.00)</u>	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	10,923,362.99
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	10,923,362.99

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

						/ төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	42,154,984.00	124,626,419.90	103,115,009.27		269,896,413.17
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	42,154,984.00	124,626,419.90	103,115,009.27	-	269,896,413.17
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-		-

C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	13,923,315.95	-	13,923,315.95
C08	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	42,154,984.00	124,626,419.90	117,038,325.22	-	283,819,729.12
D01	2022 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	42,154,984.00	124,626,419.90	117,038,325.22	-	283,819,729.12
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	4,506,411.28	-	4,506,411.28
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	42,154,984.00	124,626,419.90	121,544,736.50	-	288,326,140.40
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(4,506,411.28)	-	-	(4,506,411.28)
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	1,009,113,710.40	-	1,009,113,710.40
D09	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	42,154,984.00	120,120,008.62	1,130,658,446.90	-	1,292,933,439.52

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	316,092,500.00	268,365,004.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	316,092,500.00	267,209,004.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	315,492,500.00	266,609,004.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	222,855,700.00	203,904,642.37
210101	Үндсэн цалин	153,998,800.00	147,528,387.77
210102	Нэмэгдэл	43,869,400.00	38,562,423.60
210104	Урамшуулал	24,987,500.00	17,813,831.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,715,500.00	27,060,279.40
210201	Тэтгэврийн даатгал	21,641,200.00	19,257,480.80
210202	Тэтгэмжийн даатгал	2,286,600.00	1,959,166.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,796,800.00	1,567,432.40
210204	Ажилгүйдлийн даатгал	453,800.00	383,271.98
210205	Эрүүл мэндийн даатгал	4,537,100.00	3,892,928.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол	20,632,000.00	18,416,462.37

	зардал		
210301	Гэрэл, цахилгаан	1,680,000.00	1,156,142.37
210302	Түлш, халаалт	18,700,000.00	17,260,320.00
210303	Цэвэр, бохир ус	252,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	7,150,300.00	6,374,100.00
210401	Бичиг хэрэг	500,000.00	500,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,524,500.00	2,523,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	473,700.00	350,000.00
210404	Ном, хэвлэл	61,700.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,500,000.00	910,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,090,400.00	2,090,400.00
2105	Нормативт зардал	30,047,000.00	8,616,420.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	56,600.00	56,600.00
210502	Хоол, хүнс	29,439,800.00	8,009,220.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	550,600.00	550,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	116,100.00	42,000.00
210702	Дотоод албан томилолт	116,100.00	42,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	529,900.00	230,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	529,900.00	230,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,446,000.00	965,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	977,100.00	965,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,468,900.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	600,000.00	600,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	600,000.00	600,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	200,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	600,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	1,156,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	1,156,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	1,156,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	313,876,962.37
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	294,460,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	294,460,500.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	19,416,462.37
132001	Орон нутгийн төсвөөс	-	19,416,462.37
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		10,923,362.99

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	2,395,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	2,395,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	2,395,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,395,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,395,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	2,395,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	2,395,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	2,395,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Гурванбулаг сумын Цэцэрлэг нь 2022-2023 оны хичээлийн жилд эрхлэгч-1, багш-5, туслах багш-5, дуу хөгжим багш-1, арга зүйч-1, тогооч-2, сантехникч-1, манаач-1, нярав-1, нягтлан бодогч 0.5 орон тоотой, хүүхэд өдрийн тоо 13.8 мянга, нүүдлийн гэр цэцэрлэгт 0.5 мянган хүүхэд хамрагдсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Монгол улсын Үндсэн хууль, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Татварын ерөнхий хууль зэрэг бусад эрх зүйн акт, тогтоомжуудыг мөрдөж ажилладаг

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Гурванбулаг сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккуруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/424 дүгээр захирамжаар баталсан "Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөн ажилладаг. Үйл ажиллагаанд нийцэж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Гурванбулаг сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос өөрчлөлт ороогүй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	10,923.3	10,923.3
Авлага	0.0	0.0	0.0
Бараа материал	72,351.2	86,204.0	13,852.7
Үндсэн хөрөнгө	211,468.5	1,196,466.9	984,998.4
Нийт хөрөнгө	283,819.7	1,293,594.2	1,009,774.5
Өр төлбөр	0.0	660.8	-660.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	241,664.7	1,292,933.4	1,051,268.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	241,664.7	1,293,594.3	1,051,929.5

Дээрх хүснэгтээс үзэхэд:

- ✓ Бараа материал эцсийн үлдэгдэл өмнөх оны эцсийн үлдэгдлээс 13,852.7 мянган төгрөгөөр өссөн нь хүүхдийн хоолонд зарцуулагдаагүй мах, хүнсний материал, цэцэрлэгийн өргөтгөлийн барилга ашиглалтад оронтой холбоотой аж ахуйн шинжтэй материалын үлдэгдэл зэрэг нөлөөлжээ.
- ✓ 2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 75 хүүхдийн ортой 995,938.5 мянган төгрөгийн цэцэрлэгийн барилгын өргөтгөл баригдаж, улсын комисс хүлээж авсан, Боловсролын ерөнхий газраас үнэ төлбөргүй шилжүүлсэн 6,372.6 мянга, иргэн Ц.Отгонтуяагаас 7.5 мянган төгрөгийн хөрөнгө хандиваар бий болсон байна. Мөн 5,283.6 мянган төгрөгийн анхны үнэ бүхий уурын зуухны барилгыг аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 12/14 тоот тогтоолоор акталсан зэрэг нөлөөлжээ.
- ✓ Ажиллагсдаас суутгаж авсан хамтын сангийн суутгалыг дутуу шилжүүлсэн 45.0 мянга, сургалтад хамрагдахад зарцуулсан шатахууны өглөг 615.8 мянган төгрөгийн өглөг үүссэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төслийг мянган төгрөгөөр төлөвлөж хүргүүлсэн.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсвийг улсын төсвөөс 326,595.4 мянга, орон нутгийн төсвөөс 52,644.3 мянган төгрөгөөр батлагдсан.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	71801-Сургуулийн өмнөх боловсрол	326,595.4	315,672.0	10,923.3	96.6%
1	81605-Эрүүл мэндийг дэмжих	1,100.0	1,100.0	0.0	100%
2	81807-Цэцэрлэгийн хүүхдийн хоол	42,161.2	39,632.6	2,528.5	94%
3	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	1,680.5	1,674.0	6.5	99.6%
4	81823-Боловсролын байгууллагын багш	1,100.0	1,100.0	0.0	100%
5	81834-Боловсролын стандарт, сургалтын	256,326.4	249,629.2	6,697.2	97.4%

6	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа	24,227.3	22,536.1	1,691.1	93.0%
	71801-Сургуулийн өмнөх боловсрол	52,644.3	52,634.2	10.02	99.9%
7	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	41,797.0	41,787.1	9.8	99.9%
8	80112-Нийтлэг үйлчилгээ	10,847.3	10,847.1	0.1	99.9%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Нэмэлт санхүүжилтийн дансаар төгсөгчдөөс 2,395.0 мянган төгрөгийн хандиваар санхүүжигдсэн.

Хандиваарх орлогын төсөв, гүйцэтгэл, орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Гурванбулаг сумын Цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, одоо ашиглагдаж байгаа үлдэх өртөггүй, хөрөнгийн ашиглах хугацааг шинэчлэн тогтоох, бараа материалыг холбогдох зөв данс бүртгэлд тусгаж тайлагнаж байх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь ТАГ-ын аудитор Б.Золжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган сумын Хоёрдугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь ТАГ-т 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 05 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсөв 326,595.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 4,898.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар буюу 3,674.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

2022 оны 12 сард Цэцэрлэгийн хүүхдийн хоолонд зориулж 5,048,300.0 төгрөгийн 531.4 кг мах нөөцөлсөн. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн

агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 24 удаагийн 327,448,000.0 төгрөгийн орлогын гүйлгээ мэдээлэхээс 4 удаагийн 19,992,200.0 төгрөгийн орлогын гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2 удаагийн 14,899,300.0 төгрөгийн зарлага, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 19 удаагийн 226,174,211.0 төгрөгийн тушаал, шийдвэр мэдээлэхээс 8 удаагийн 222,749,532.0 төгрөгийн шийдвэрийг мэдээлээгүй.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийг үнэн зөв, бодитой, иж бүрэн, тогтоосон хугацаанд мэдээлж байх албан шаардлага хүргүүлэх

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Шатахууны зарцуулалтыг шалгахад авто машины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг 527.2 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант хугацаанд завсрын аудит хийгээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

2021 оны санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар:

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	0.0	1	0.0	100%
Зөвлөмж					
Нийт дүн	1	0.0	1	0.0	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийг зөв данс бүртгэлд тусгасан эсэх, бүртгэл хөтлөлт, ашиглалт, зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,558.5 мянган төгрөгийн алдаа¹ гарсныг тайлангийн хугацаанд залруулж байх, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, одоо ашиглагдаж байгаа үлдэх өртөггүй, хөрөнгийн ашиглах хугацааг шинэчлэн тогтоох, бараа материалыг холбогдох зөв данс бүртгэлд тусгаж тайлагнаж байх зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Зам тээвэр хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан "Авто машины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-ыг 527,265.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 6 дугаар зүйлийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390-р тушаалын 1-р хавсралт "Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-ыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Хэтрүүлэн зарцуулсан 527,265.0 мянган төгрөгийг аймгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох

5.2 Албан шаардлага

2022 оны 12 сард Цэцэрлэгийн хүүхдийн хоолонд зориулж 5,048.3 төгрөгийн 531.4 кг мах нөөцөлсөн.

Шийдвэрлэсэн нь:

Цэцэрлэгийн хүүхдийн хоолны материалыг хүүхдийн тоо, хичээллэх өдөрт тохируулан худалдан авалт хийж байх, албан шаардлага хүргүүлэх

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудлаар:

1.1 Илрүүлэлт Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, одоо ашиглагдаж байгаа үлдэх өртөггүй, цаашид ашиглах хөрөнгийн ашиглах хугацааг шинэчлэн тогтоогоогүй,

Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, одоо ашиглагдаж байгаа үлдэх өртөггүй, хөрөнгийн ашиглах хугацааг шинэчлэн тогтоох зөвлөмж өгөх

2. Бараа материалтай холбоотой асуудлаар

2.1 Бараа үйлчилгээний бусад зардлаас шатахуун худалдан авч шатахууныг бараа материалын түлш шатах тослох материалын дансаар биш нөөцийн бараа дансаар бүртгэж тайлагнасан.

Өгсөн зөвлөмж:

Бараа материалыг холбогдох зөв данс бүртгэлд тусгаж, тайлагнаж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 06 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

